

ХРИСТИТГЭЛ ХЭМЭЭХҮЙН УЧИР

Л.Төмөрхуяг (Докторант)

МУИС НШУС

Шашин судлалын тэнхим

В.Дүгэрмаа (Ph.D)

Түлхүүр үг: "Христианство", "Христитгэл", "Христосын шашин", "Христийн шашин", "Christianity", "Эрхүүд"

Товч утга: Аливаа улс үндэстний соёлын амьдрал, хэл соёлд шинэ үзэл санаа, үзэгдэл юмс, техник технологи нэвтрэхэд тэдгээрт нэр оноох зүй ёсны шаардлага гарч ирдэг. Эл асуудлаар тухайлбал өөрийн гэсэн хэрэглээний хүрээтэй бөгөөд тэр хүрээндээ хэзээний хэвччихсэн боловч хэл шинжлэл, шашин судлал болон нийгмийн оюун санааны амьдралд нэг мөр болон шийдэгдээгүй байгаа гэж зарим нэгний үздэг "Christianity" (eng), оросоор "Христианство" (рус) гэдгийг "Христитгэл" хэмээн монголчилсон учрыг энд өгүүлэх юм.

Энэ үгийг Орос Монгол тольд (3): ХРИТИАНСТВО – христосын шажин; Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд (4): ХРИСТОС 1. Загалмайтны шашин: **христосын шашин** (христосын шашны үзэл онол, сургаал); Britanica ширээний нэвтэрхий тольд (6): **Христийн шашин** (Christianity) гэхчлэн энэхүү үзэл онол, итгэл үнэмшил, шашин шүтлэг манайхны хувьд танил бус байсан өмнөх үеийн ойлголтоор голдуу оноосон байдаг.

Харин энэ үг монгол хэлний хувьд тийм ч шинэ үг биш, монгол түмний хувьд тийм ч шинэхэн үзэгдэл бус гэдгийг илтгэсэн "Эрхүү", "Эрхүүн", "Эрхүүд" гэх үгүүд бий. "Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан монгол үгийн дээж" хэмээх толь бичгээс үзвэл: (2) **ЭРХҮҮД** (нэр) 1. Христосын шашин буюу шашинтан. "erk un bolba" (христосын шашинтан болов). 2. Монголын нэг овгийн нэр; эрт үед тэр овогтон энэ шашныг шүтдэг байснаас ийнхүү нэрлэгджээ; Найман, Хэрэйд аймгийнхан эрхүүдийн шашныг шүтэж байжээ. Түүнчлэн, Дэлгэрэнгүй тайлбар тольд (4) **ЭРХҮҮД** хуучирсан 1.Христосын шашинтныг нэрлэх нэр: 2. Уг шашныг шүтэж байсан Монголын эртний овгийн нэр гэжээ. Энэ бүгдээс үзвэл **эрхт** Дээд Тэнгэрбурханд итгэж явж, **Эргүнэ** күнээс ирсэн эцэг овгийн маань **эрх** мэдэл, **эрч** хүч, Ариг-Усны эрэг түшсэн **Эрхүү** хот гээд эртний ул улбаа хөвөрч байх шиг харагддаг. Мөн **ЭРХҮҮД** гэдгийг **ТЭРСҮҮД** гэх утгатай, түрэг гаралтай үг гэсэн таамаг дуулддаг. Христитгэлийг Христосын шашин болгохыг эсэргүүцээнийх нь улмаас 16-р зууны реформистуудад оноосон гэрхүү **ПРОТЕСТАНТ** гэдэг нэртэй угшил нэгтэй байж болохоор харагддаг ч хүн төрөлхтнийг мөнх тамын ялаас нь хэлтрүүлэхээр **ТОМИЛОГДСОН АВРАГЧ** буюу **ХРИСТ** хэмээх язгуураас зайлах аргагүй нь тодорхой.

Гэхдээ Христитгэлийн үндсэн Бичвэр болох Библид "CHRISTIANITY" гэдэг энэ үг байхгүй бөгөөд тухайн улс үндэстний хэл соёл, шашин судлалын хэрэглээ болон гарч ирсэн үг. Харин Шинэ гэрээнд **ХРИСТИТГЭГЧ** буюу Христэд итгэгч хүнийг нь заасан **Χριστιανος**-**Χριστιανος** гэдэг үг: (грек, еврейгээр бичсэн үгийн дуудлагыг богино зураасны араас латинаар галиглав. Мөн еврей үгийг өмнө нь кирилээр галиглаж хашилтад хийлээ.) Үйлс 11:26 "Дагалдагчдыг анх удаагаа Антиоход Христитгэгчид гэж нэрлэх болов"; Үйлс 26:28 Агрипп,

Паулд - Чи намайг богино хугацаанд Христитгэгч болгох нь ээ ; 1Петр 4:16. “Христитгэгч гэдгээсээ болж зовдог бол бүү ич” гэж 3 удаа гардаг. Өмнөх буюу 2004 оны монгол орчуулгад энэ үгийг “Христийнх” гэсэн байгаа нь “Χριστου”-Hristou буюу “of Christ”, “Christ’s” хэмээн Шинэ гэрээнд 100 гаруй удаа гардагтай дүрмийн хувьд тохирч байгааг харгалзан ийнхүү өөрчилсөн болой.

Энд хэргийн гол учиг болоод байгаа “ИТГЭЛ” гэдэг үгийг оруулан хэрэглэх үндэслэлүүд гэвэл:

Нэгдүгээрт. Бүтээгч ЭЗЭН бээр бусад бүх бүтээлээс онцгойлон, Өөрийнхөө төрхөөр, Өөртэйгөө адилханаар хүнийг бүтээхдээ ерөнхийдөө Өөрийг нь мэддэг, ойлгодог, хүлээн зөвшөөрдөг, сайндаа л сүсэглэдэг төдий биш харин Өөрт нь итгэж, Өөртэй нь харилцдаг байлгахыг зорьсон гэдэг нь Библийн үнэн. ИТГЭЛ гэдгийг Монгол хэлний тайлбар толиудаас үзвэл 1. Бат нот үнэмших санаа, сэжиггүй үнэмшил, найдлага. 2. Тэнгэр бурханд итгэх үнэмшил гэж тун тодорхой хэлжээ. Даяаршлын үеийн зонхилох хэл болж буй англиар: итгэл - affiance, belief, certainty, confidence, conviction, credence, credit, credo, creed, faith, hope, hopefulness, persuasion, refug, trust гэхчлэн хамгийн өргөн утга агуулгыг илэрхийлж байна.

Анхны хүн гэм нүглийн улмаас ЭЗЭНээсээ салсан үед нь ч чухам үүний тулд л хууль дүрэм гаргаж, хурга төлөг бусад амьтнаар тахил өргөх ёс жаяг буюу Хуучин гэрээг байгуулсан. Үүнийгээ дагаж сахих хүн ховор болохоор нь цорын ганц Хүүгээ буюу Томилогдсон Аврагч Эзэн Христ Иэсүсийг энэ дэлхийд ирүүлж хүн төрөлхтний нүгэл ялын Золиос болгон өргөх Шинэ гэрээ хийсэн. Энэ хоёрыг нэгтгэсэн Хөлгөн Бичвэр буюу Библийн гол цөм нь болох туйлын ИТГЭМЖИТ ЭЗЭН Тэнгэрбурханд буюу энэ дэлхийд ирсэн Христийн авралын ажилд туйлбартай ИТГЭЖ Түүнийг дагаснаар элдэв муугаас төдийгүй эцсийн өдөр ирэх үхэл тамын ялаас хэлтрэх боломжтойг илтгэсэн “ИТГЭ” хэмээх үндэс бүхий үг Ариун Библид 1000 гаруй удаа гардаг. Үүнээс: итгэх, найдах, дэмжих г.м. утга бүхий “ааман” (אמן - aman) гэдэг үйл үг анх Эхлэл 15: 6-д “Тэгээд Абрам, ЭЗЭНд итгэсэнд Эзэн үүгээр нь түүнийг зөвд тооцов” гэснээс эхлээд 45:26 “Тэгээд эцэгтээ - Иосеф одоо ч амьд байна. Тэрээр Египетийн бүх нутгийн захирагч болжээ гэсэнд Иаков тэдэнд итгээгүй тул түүний зүрх шимширлээ”, Египетээс гарсан нь 4:1 “Тэгэхэд Мосе хариулан - Хараач, тэд надад итгэж миний үгийг сонсохгүй харин “ЭЗЭН чамд үзэгдээгүй шүү дээ” гэж хэлж магад гэв” гэхчлэн 105 удаа гардаг. Энэ үг явсаар “амээн” (אמן - amen) буюу “үнэн”, “зөв”, “зүйтэй” гэсэн үг үүсгэсэн байдаг. Эндээс гаралтай. “тогтвор”, “туйлбар”, “итгэмжит чанар” гэх утга бүхий “имунаах” (יְמוּנָה - imunah) гэдэг үг Египетээс гарсан нь 17:12 “...Тийнхүү нар жаргах хүртэл түүний гар тогтвортой байв” гэснээс эхлээд Хабаккук 2:4 “...Харин зөвт хүн итгэлээрээ амьдарна” гэдэг хүртэл 49 удаа гардаг нь мөн “итгэл”-ийн үндэс болдог. “Итгэгч” гэсэн үг Ариун Библи монгол орчуулгад 70 гаруй удаа, үүний 4-өөс бусад нь Шинэ гэрээнд гарч байна. Шинэ гэрээнд “πιστις-pistis” - “итгэл” буюу “итгэл үнэмшил” гэдэг нэр үг Матай 8:10-аас Илчлэл 14:12 хүртэл 243 удаа; “πιστευό-pisteuo” буюу “итгэх” гэдэг үйл үг Мат.8:13 -аас Иуда 1:5 хүртэл 241 удаа; “πιστός-pistos” буюу “итгэгч”, “итгэлтэй”, “итгэмжит” гэсэн тэмдэг нэр Матай 24:45-аас Илчлэл 22:6 хүртэл 67 удаа; үүний сацуу “ολιγοπιστος-oligopistos” буюу “итгэл багатай”, “өчүүхэн итгэлтэй” хэмээн Матай 6:30, 8:26, 14:31, 16:8, Лук 12:28. г.м. 5 удаа гарч байна.

Хоёрдугаарт. Орос хэлний -ство, -ние- ие -ия -ость, -изм, англи хэлний -nity, -ty, -у, -tion, -sion, -ture гэхчлэн үг бүтээх залгавруудыг бид -лал4, -лалт4, -лга4 гэхчлэн голдуу буулгах сацуу тухайн үзэгдэл юмсын онцлогийг харгалзан нэр оноох үндсэн аргачлалтай явж ирсэн харагддаг. Тухайлбал: производство – production, manufacture - үйлдвэрлэл, электрификация - electrification - цахилгаанжуулалт, ответственность –responsibility- хариуцлага мөн патриотизм - patriotism - эх оронч үзэл, суверинитет – sovereignty - бүрэн эрхт байдал, независимость – independence - тусгаар тогтнол, география – geography - газарзүй гэхэд энд үзэл, байдал, тогтнол, зүй гэхчлэн чухам юу болохыг нь тодруулан бас нийлүүлж нэрлэдэг ёсоор Христианство -

Christianity – Христитгэл хэмээн дүйлгэсэн болой. Дээр дурдсан “Британника” тольд: YMCA буюу Young Men’s Christian Association гэдгийг Христ Итгэлт Залуучуудын Холбоо, Woman’s Christian Temperance Union гэдгийг Христ Итгэлт Эмэгтэйчүүдийн Согтууруулах Ундааг Тэвчих Холбоо гэхчлэн орчуулсан байгаа нь үүнийг бас баталгаажуулах буй. Харин энд Итгэлт гэдгийг салангид бичсэн нь ялангуяа Христэд итгэгч хүнийг нэрлэхээр өмнө нь тодотгол орох тохиолдолд “Өөр бусад Христэд итгэгч”, “Монголын Христэд итгэгч” гэх мэт давхар Христ гаргаж ирэх аюул үүсгэдэг тал бий. Нөгөөтээгүүр “верующий во Христе”, “believer in Christ” гэдгийг “Христэд итгэгч” гэж нөөцөд үлдээх эрх төрөлх хэлэнд маань бий.

Холбоо юмуу хэд хэдэн үгээр нэр томъёо үүсгээд тус тус салангид бичих нь орчин цагийн монгол хэлнээ ихэд зуршмал болсон. Гэтэл дээхнэ үед бол аль болох нийлүүлж, түүгээр ч барахгүй үгийн язгуур залгавар хоёрыг утсарч шинэ нэр үүсгэх сайн арга байжээ. Жишээ нь: “эр бөднө” шувууг “эрдүнэ”, таван эгшгийн нэг болох туйлын нам булингар аялгууг “гүн дагуун” гэдгээс ургуулаад “гүндээгүн”, Хойд Америкаар голдуу нутагтай, хонь сарлаг хоёрын эрлийз төрхтэй нэгэн амьтныг хонины толгойд сарлагийн сүүл залгаж, эгшиг зохицуулаад “холог” гэх буюу сарлагийн толгойд аргалийн сүүл холбоод “саргаль” хэмээсэн сайхан туршлага байсныг хожуухан нь орос “овцебык” бараадуулан “хонин бух” болгосноор “хуц” юмуу “одой бух” гэж эндүүрэхүйц ухрал хийсэн явдал ч бий. Басхүү, “фотосинтез” гэдгийг “гэрэл нийлэг” гэхчхээр, ялангуяа цахим төхөөрөмж хөгжсөн өнөө цагт үг хайгаад ирэхээр “гэрэл” гэдэг нэр үг, “нийлэг” гэсэн захирах хүсэх үйл үг гарч ирж төөрүүлэх нь өлхөн тул “гэрэлнийлэг” гэж бичих болсончлон ядаж гол гол нэр томъёог бүтээсэн үгс нь нийлж, голбаалчлалын жагсаалд зарим өнцөг маань нийлвэл ч нийлэг. Энэ үүднээс Ариун Библийн хянан засварлаж байгаа хувилбарт: מַלְאָךְ-mlak буюу ἄγγελος-angelos гэдгийг “тэнгэрэлч”, בַּשָּׂר-basar буюу εὐαγγέλιον-euangelion –ыг “сайнмэдээ”, מִלְאָךְ-mulah буюу περὶ τομῆ-περιτοме хэмээхийг “хозлол” болгосон жишээ цөөнгүй бий.

Гуравдугаарт. Итгэл бол асар их хүч гэдгийг Марк 9:23 “...Итгэдэгт нь бүх юм боломжтой” гэж тодорхойлсон. Ерөөсөө Библид гарч байгаа эдгэрэл, чөлөөлөлт, амилал, хувирал гээд бүхий л гайхамшиг тэдгээрийн оргил болох жинхэнэ АВРАЛ зөвхөн ИТГЭЛ хэмээх шижимээр ЭЗЭНд холбогдон бүтдэгт л хэргийн учир байгаа юм. Харин шашины тухайд бол Тэрхүү Бүтээгч ЭЗЭН Өөрөөс нь өөр ямар нэгэн бурхан шүтээн, бусад бүтээл, шашин шүтлэг дагасан хүний нүглийн шийтгэлийг гурав дөрвөн үед нь хүртэл эдлүүлэх хартай Эзэн гэдгээ (Египетээс гарсан нь 20:5, 34:14, Дэд хууль 4:24, 5:9, 6:15, Иошуа 24:19, Езекиел 39:25, Нахум 1:2 г.м.) олонтаа, тов тодорхой хэлсэн байгаа. Үүнийгээ Шинэ гэрээнд Колоссай 2:23-аар бүр батжуулж “Эдгээр нь өөрсдийн бий болгосон шашины үзэгдэл болоод хуурамч даруу байдал мөн биенийг зовоох байдлаар мэргэн ухаан мэт үзэгдэвч, үүнд махбодын хүслийн эсрэг ямар ч нэмэр үгүй юм” гэжээ. Энэхүү “ἐτελιотρεςκία”-eteliotreskia буюу “өөрсдийн буй болгосон шашин” гэдэг үг Библид ердөө л ганц гардаг. Мөн Үйлс 25:19-д л ганц гарах “δεϊσιδαϊμονία”-deisidaïmonia гэдгийг англиар “religion”, монголоор “шашин” гэжээ. Бас Шинэ гэрээнд ердөө л 4 удаа гардаг бөгөөд “ἔс ёслол” юмуу “айж дагжих” гэсэн утга бүхий “θρησκεία”-treskia хэмээх грек үгийг Үйлс 26:5-д “шашин”, Колоссай 2:18, Иаков 1:26, 27-д “сүсэглэл” гэсэн буй. Ингэхлээр шашин бүгд итгэл мөн боловч Библийн дагуух жинхэнэ Христитгэл бол шашин байх боломжгүй юм. Гэхдээ энэ нь Еховагийн гэрч гэхчлэн зарим “культ”, “сектийнхэн” өөрсдийн итгэл бишрэлийг “жинхэнэ шашин” гэж тодорхойлдгийг мөн бусад зарим тольд (5, 7) Christianity-Христосын шашин, Загалмайтны шашин гэснийг бид үгүйсгээгүйн адил аливаа гадаад үг хэрэглээ, эх бичгээсээ хамааран хэд хэдэн орчуулгатай байж болдог тэр л ёсоор Библийн дагуу Христэд итгэх итгэлийг ХРИСТИТГЭЛ хэмээн тогтсоныг маань хэн нэг нь хөндлөнгөөс шургаж ороод эсвэл бүр судалж оролцолгүйгээр үгүйсгэх боломжгүй гэдгийг цохон тэмдэглэх байна.

Дүгнэн хэлвэл:

1. Дэлхийн хамгийн олон хэлээр, хамгийн олон удаа, хамгийн олон хувиар хэвлэгдэн гарсаар байгаа Хөлгөн бичвэр Библийн доторх болон түүнтэй холбоотой үг, нэр, нэр томъёо, үг галиглал зэргийн судалгааг хэлшинжлэлийн орчин үеийн төвшинд, гүнзгийрүүлэн хийж, Монголын жишиг тогтоох нь нэн чухал бөгөөд зайлшгүй шаардлагатай байна.

2. Оросоор Христианство англиар Christianity гэдгийг Христитгэл, Христийн шашин, Христосын шажин гэхчлэн тухайн бичвэр дэх хэрэглээг харгалзан орчуулах.

3. Христианин, Christian гэсэн нэр үгийг Христитгэгч, шаардлагатай үед нь Христосын шажинтан, Христ сүсэгтэн гэхчлэн орчуулах.

4. Христианский, Christian гэх тодотгол буюу тэмдэг нэрийг христэч, христитгэлт, Христийн шашины хэмээн тухайн бичвэр дэх хэрэглээг харгалзан орчуулах.

НОМ ЗҮЙ

1. АРИУН БИБЛИ. МБОХ. 2004 ба АБН-ийн Хянан засварлаж буй хувилбар.
2. Дамбажав И. нар. ОЮУН БИЛГИЙН МЭЛМИЙГ НЭЭГЧ АЯЛГУУ САЙХАН МОНГОЛ ҮГИЙН ДЭЭЖ. (Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь). УБ. 2006.
3. Дамдинсүрэн Ц., Лувсандэндэв А. ОРОС МОНГОЛ ТОЛЬ. БНМАУ-ын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн. УБ. 1982.
4. МОНГОЛ ХЭЛНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛБАР ТОЛЬ. Монгол Улсын ШУА. УБ. 2008.
5. Чинбат Э. АНГЛИ МОНГОЛ ТОЛЬ. УБ. 2011.
6. BRITANNICA ШИРЭЭНИЙ НЭВТЭРХИЙ ТОЛЬ. Нерко. 2011.
7. ENGLISH-MONGOLIAN CHRISTIAN CATHOLIC DICTIONARY. УБ. 2008.

ABSTRACT

1. It is of utmost importance to research the words of the Bible, the words related to the Bible, the names contained in it, and its terms and spelling (which has been translated into the most languages, the most often, and most printed in the world) at a modern and deep level and then establish these at a Mongolian standard.

2. Translating the word “Христианства” (“Christianity” in English) into “Faith in Christ,” “Christian Religion,” and “Religion of Christ” must be done through the usage of that scripture itself.

3. The word “Христианин” (“Christian”) is translated “Faith in Christ.” However, if there is a need, the word is translated into “Religion of Christ” and “Christ Believer”.

4. Translating the word “Христианский” (“Christian”) into “A person who believes in Christ,” “Faith in Christ,” and “Christian Religion” must be done through the usage of that scripture itself.